

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 3 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 10 цаг 04 минутад эхэлж, 11 цаг 04 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам батлах тухай	<p>Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8, 35 дугаар зүйлийн 35.1.3, 35.1.9, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 1.3-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн нэгдүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. “Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтын үнэлгээ, дүн гаргах заавар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтын дүнгийн хуудас”-ны загварыг гуравдугаар хавсралтаар, “Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэнийг нөөцөд бүртгэх жагсаалтын загвар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар, “Бүртгэлийн хуудас”-ны загварыг тавдугаар хавсралтаар, “Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтын зохион байгуулалтын хяналтын хуудасны загвар”-ыг зургадугаар хавсралтаар тус тус батлах.</p>

		<p>2. Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнийг сонгон шалгаруулахдаа энэхүү журам, зааврыг баримталж ажиллахыг Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд үүрэг болгох.</p> <p>3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан “Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 61 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Сүхбаатар аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Сүхбаатар аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Сүхбаатар аймагт 2014 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Болортуяагийн Золзаяа, Сүхчулууны Түмэнбаяр нарыг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, Отгоны Мөнхзулыг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх</p>

		<p>хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн Болортуяагийн Золзаяаг Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн Уулбаян сумын Татварын улсын байцаагчийн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн Отгоны Мөнхзулыг Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын хоёр дахь хэсэгт заасан Болортуяагийн Золзаяа, Отгоны Мөнхзул нарыг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Сүхбаатар аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Нөөцөөс хасах тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх хэсгийг баримталж, 2013 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай" 167 дугаар тогтоолын 1, 9 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 1 дүгээр сарын 30-</p>

		<p>ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлэх тухай" Төрийн албаны зөвлөлийн 167 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-ын "8; 112691; Хөдөлмөрийн хэлтэс; Хөдөлмөрийн хэлтэс; Мэргэжилтэн; Жижиг дунд үйлдвэрлэлийн бодлого, төсөл, хөтөлбөр хариуцсан" гэсний "Шакетай Аюесхан; 73", мөн тогтоолын 9 дүгээр хавсралтын "Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн жагсаалт"-ын "3; 112691; Хөдөлмөрийн хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс; Мэргэжилтэн; Жижиг дунд үйлдвэрлэлийн бодлого, төсөл, хөтөлбөр хариуцсан" гэсний "Шакетай Аюесхан; 73" гэсэн хэсгийг тус тус хасах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга С.Ганчимэгээс гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга С.Ганчимэгээс тус аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн "Хариуцлага тооцуулах тухай" 2013 оны 38 дугаар тогтоолыг эс зөвшөөрч, Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам"-ын "Нэг" дэх хэсгийн 3.6-д заасныг</p>

		<p>удирдлага болгон:</p> <p>Төв аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар Зөвлөлийн “Хариуцлага тооцуулах тухай” 2013 оны 38 дугаар тогтоолыг төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шалгах ажиллагааны шат дараалсан үйл ажиллагааг хангаагүй, эрх зүйн чадамжгүй гэж үзсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	<p>Гадаад харилцааны яамны Олон Улсын байгууллагын газрын захирлын удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчдад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Гадаад харилцааны яамны Олон Улсын байгууллагын газрын захирлын албан тушаалд Гончигийн Ганболдод дүгнэлт гарган нэр дэвшүүлж, томилуулахаар Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Цогтсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ